



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/03

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам" А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хайдал овогт Мижиддоржийн Чинбат нь (ЕЙ70020730) Сүмбэр сумын 2 дугаар багийн Агропарк 1-105 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 654м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул Сүмбэр сумын 2 дугаар багийн Агропарк 1-105 тоотод байрлах 654м² газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (М.Чинбат)-д үүрэг болгосугай.


3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй иргэн М.Чинбатад эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/02 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
0.7 сарын 08-ны өдрийн 1/03...дугаар
захирамжийн хавсралт



Хайдал овогт Мижиддоржийн Чинбатын эзэмшил
газрын хугацааг сунгаж буй газрын байршлын зураг

Сумын нэр	Багийн дугаар	Газрын хэмжээ /м ² /	Эзэмших хугацаа /жил/	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
Сүмбэр	2	654	15	Гэр бүлийн хэрэгцээ	Агропарк 1-105

